



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/25

Арвайхээр сум

Хэрэгжилтийг хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт батлах тухай” А/122 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, жил бүрийн 11 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд орон нутагт хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглох, цуцлах, хяналт тавьж ажиллахыг сумын онцгой комисс, сум, багийн Засаг дарга нар, аймаг, сумдын Морин спорт уяачдын холбоо (Ю.Үнэнбүрэн)-д үүрэг болгосугай.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Г.Чимэддагва), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Г.Пүрэвдорж)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0051